

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Биелэлт	Хувь
НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
1.1	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	-	Хэрэгжилтийн хувь	ЗГҮАХ-ийн хэрэгжилт 83.7 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 онд 6 удаа тооцож ажилласан. Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт оны эцсийн байдлаар 94.2%-тай хэрэгжсэн байна.	100
1.2	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах.	-	Хэрэгжилтийн хувь	АЗДҮАХ-ийн хэрэгжилт 85 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцож, хугацаанд нь цахим хэлбэрээр хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 111 арга хэмжээний хэрэгжилтийг тооцоход 100%-тай 62 арга хэмжээ, 90%-тай 33 арга хэмжээ, 70%-тай 13 арга хэмжээ, 30%-тай 1 арга хэмжээ, хэрэгжилт тооцох боломжгүй, үр дүнгүй 2 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 91.8%-тай байна.	100
1.3	Сумын Засаг даргын 2021-2024 оны “Хөгжлийн төлөө 2” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Сумын Засаг даргын “Хөгжлийн төлөө II” хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт гаргуулан ажиллаж байна.	100

				88.1 хувьтай хэрэгжсэн.		Сумын Засаг даргын “Хөгжлийн төлөө II” хөтөлбөрийн 70 зорилт, 145 арга хэмжээний хэрэгжилтийг тооцоход 100%-тай 121 арга хэмжээ, 80%-тай 20 арга хэмжээ, хэрэгжилт тооцох боломжгүй, үр дүнгүй 2 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 92%-тай байна.	
1.4	Аймаг, сумын Засаг даргын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	Гэрээний хэрэгжилт 85-тай хэрэгжсэн байна.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан 2023 оны гэрээний заалтуудыг оны эхнээс эзэнжүүлэн, байгууллагын дарга, төрийн албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар 6 зорилтын хүрээнд 148 арга хэмжээний биелэлтийг 92.4%-иар хэрэгжүүлэн ажилласан байна.	100
1.5	Бүх нийтийн эрх зүйн боловсрол дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	ОНХС	Хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 83%-тай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр тооцон аймгийн хууль эрх зүйн хэлтэст мэдээлж ажилласан. 2023 оны жилийн байдлаар хэрэгжилт 95 %-тай байна. Хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн багийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөөг гаргаж, тайлан мэдээг хугацаанд мэдээлж ажилласа. Эрх зүйн баг нь аймгийн Шилдэг эрх зүйн багаар шалгарсан амжилт гаргасан. Хөтөлбөрийн хүрээнд сургалт нөлөөлөллийн ажлыг 30 удаа зохион байгуулж, 2710 иргэнийг хамруулан ажилласан байна.	100
1.6.	“Зөв дадал-Архигүй” орчин хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	ОНХС	Хэрэгжилтийн хувь	80 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Хөтөлбөрийн хүрээнд Архины хамааралтай иргэдийн судалгаа болон архи согтууруулах ундаа хэрэглэдэг, бөөгнөрөл үүсгэдэг айл	100

						<p>өрхийн судалгааг нарийвчлан гаргасан. Архидан согтуурдаг, бөөгнөрөл үүсгэдэг айл өрхөд хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Мөн архины хамаарал бүхий иргэдийн хүүхдүүдтэй уулзаж ярилцан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Цагдаагийн хэсэгтэй хамтран архины хамааралтай эмэгтэйчүүдийн ар гэрийхэн, хүүхдүүдтэй уулзаж уулзалт ярилцлага хийж, зөвлөгөө өгсөн. Архи согтууруулах ундааны хор уршигийн талаар Дашинчилэн ЭМТ-ийн фэйсбүүк хуудас, Зөв дадал-Эрүүл мэнд гэсэн цахим хуудсанд мэдээллийг байнга тавьж, цахимаар сурталчилан ажиллаж байна. ЕБС-ийн 5-9-р ангийн сурагчдын дунд “Архи тамхи шинэ үеийн сонголт биш” сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд: 5-9-р ангийн сурагчдын дунд тамхины хор хөнөөлийг таниулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. “Зөв хүн байя” сарын аяны хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд оролцсон байгуудад тусгайлан бэлдсэн (Архи түүний хор уршиг, Утаат тамхи түүний хор уршиг, Үе энгийн дээрэлхэлт, Гэр бүлийн хүчирхийлэл, Электрон тамхи, Цахим хэрэглээ) сэдвийг өгч, тухайн сэдвүүдийн хүрээнд болсон. Тэмцээнд 7 бүлгийн 42 хүүхэд</p>
--	--	--	--	--	--	--

						оролцсон. “Зөв дадал-Архигүй орчин” бүрдүүлэхээр “Өвлийн өнгө” цасны баяр-2023 арга хэмжээ,” Ханьтайгаа хамтдаа” гэр бүлийн тэмцээнийг зохион байгуулсан. Утаат болон электрон тамхи, Үе тэнгийн дээрэлхэлт сэдвүүдээр ЕБС-ийн сурагчдад 1 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 260 гаруй хүүхэд хамрагдсан.	
1.7	“Чинээлэг малчин” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	ОНХС	Хэрэгжилтийн хувь	85 хувьтай хэрэгжсэн	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	“Чинээлэг малчин” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын А/05 тоот захирамжаар байгуулж, 2023 оны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 10 сарын байдлаар 78.9 хувийн биелэлттэй байна. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас 2-р багийн малчин Г.Шижирбаатарт аялал жуулчлалыг хөгжүүлэх, гэр бааз ажиллуулах зориулалтаар 24 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн ХЭДС-с 2 өрхийг малжуулах төсөлд хамруулсан. Өндөр ашиг шимт малыг өсгөх, малын эрүүл мэндийг хамгаалах, малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий “Малчдын зөвлөгөөн 2023”-ыг зохион байгуулж, нийт 130 малчны төлөөллийг хамруулсан. Малын үүлдэр угсаа сайжруулах талаар зөвлөмжийг 105 малчинд, малжуулах төсөл бичих талаар сургалтыг 12 иргэнд, малын генетик нөөцийн тухай хууль болон бусад мэдээ мэдээллийг 27 иргэнд биечлэн өгч ажилласан байна.	100

1.8	Шинэ хөдөө хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	ОНХС	Хэрэгжилтийн хувь	85 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-аас дээш хувиар биелсэн байна.	УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ "Шинэ хөдөө-Боловсрол" төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 19 багшид зөөврийн компьютерыг олгосон.	70
1.9	Сумын бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	81.5 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-аас дээш хувиар биелсэн байна.	Бэлчээрийн даацыг бууруулах ажлын хүрээнд бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг боловсруулан батлуулж, захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн. Журмын хэрэгжилт 81.4 хувийн биелэлттэй байна.	100
1.10	Цэвэр орчин Цэмцгэр Дашинчилэн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	83 хувьтай хэрэгжсэн	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-аас дээш хувиар биелсэн байна.	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, экологийн боловсрол олгох, зөв дадалд хэвшүүлэх сургалтыг төрийн албан хаагчид болон ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан. Мөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажлын хөлсийг ЭБЦТС ТӨХК-тай гэрээ байгуулан төвлөрүүлж байна. Хогны автомашины жолооч, хог ачигчтай гэрээ байгуулан, хог ачих ажлыг хийлгэж байна. Бүх нийтийн хог цэвэрлэгээг 3 дугаар улирлын байдлаар 4 удаа зохион байгуулсан. Нэгдсэн хогийн цэгийн хогийг түрж булах ажлыг 4 удаа зохион байгуулж, 3.110.000 сая төгрөгийг зарцуулсан. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хог цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж, 85 иргэн хамрагдсан. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хог тээвэрлэх зориулалтын автомашинтай болсон.	100

1.11	Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх	-	Төлөвгөө ний биелэлт	Төсвийн орлогын төлөвлөгөө 66 хувиар хэрэгжсэн.	Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь 100 хувь хангасан байна.	2023 оны 10 дугаар сарын байдлаар 317,2 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 271,2 сая төгрөгийн оруулан төсвийн орлогын төлөвлөгөө 85.4 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелэхээр байна	70
1.12	ОНХС-ийн үйл ажиллагааг багийн түвшинд төлөвлөх ажлыг зохион байгуулах	-	Журмын хэрэгжилтийн хувь	-	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтыг журмын дагуу батлуулан ОНХС-н удирдлага мэдээллийн системд төлөвлөгөө, хэрэгжилтийг тухай бүрт нь бүрэн оруулан олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. 2023 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 83 хувиар үнэлэгдэж 59,8 сая төгрөгийн урамшуулал авах болзол хангасан.	100
1.13	ОНХС-ийн үйл ажиллагааг сумын түвшинд төлөвлөх ажлыг зохион байгуулах	-	Журмын хэрэгжилтийн хувь	-	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтыг журмын дагуу батлуулан ОНХС-н удирдлага мэдээллийн системд төлөвлөгөө, хэрэгжилтийг тухай бүрт нь бүрэн оруулан олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. 2023 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 83 хувиар үнэлэгдэж 59,8 сая төгрөгийн урамшуулал авах болзол хангасан.	100
1.14	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилт, Хугацаанд нь мэдээлсэн байдал	18 мэдээ хоцроосон.	Хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээ хоцроогоогүй байна.	Төсвийн 6 байгууллагын 300 мэдээлэл оруулахаас 291 мэдээ хугацаандаа 9 мэдээ хугацаа хоцроож оруулсан байна. Хугацаанд нь мэдээлэл байршуулалт 97 хувьтай байна.	100

1.15	Орон нутагт зохион байгуулагдах худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, улирал бүр худалдан авах ажиллагааны явцын тайланг холбогдох хэлтэст хүргүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан, тайлан мэдээг хугацаанд нь мэдээлж ажилласан.	Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг хугацаанд нь мэдээлж ажиллана.	2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 25 төсөл, арга хэмжээнд нийт 396,062.6 мян.төг зарцуулахаар батлагдсанаас 21 төсөл арга хэмжээг 212,436.0 мян.төгрөгөөр санхүүжүүлэн худалдан авах ажиллагааг 85 хувьд хүргэн ажилласан байна. Тайланг сар бүрийн 10-нд ОНӨГ-т хүргүүлсэн.	100
1.16.	Цэрэг татлагт цэргийн насны залуучуудыг бүрэн хамруулж, 2023 онд 18 иргэнийг цэргийн албанд тэнцүүлэх, 15 иргэнийг мөнгөн төлбөрт хамруулах	-	Хамруулсан иргэний тоо, тэнцсэн иргэний тоо	2022 онд 10 иргэнийг цэргийн албанд мордуулсан	Хамрагдвал зохих иргэдийн 50 хувийг хамруулна. 18 иргэнийг цэрэгт мордуулна.	2023 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын урьдчилсан үзлэгээр нийт 30 залуучууд эрүүл мэндийн үзлэгт орсоноос 15 залуучууд хугацаат цэргийн албыг хааж байна.	70
1.17.	Сумын гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах, чадавхийг сайжруулах, дадлага зохион байгуулах.	10,0 сая	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан гишүүдийн тоо	Тодорхой ажил зохион байгуулагдаагүй.	Нийт гишүүдийг сургалтад бүрэн хамруулсан байна. Чадавхи сайжирсан байна.	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангид чадавхжуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 171 иргэнийг хамруулсан. Үндэсний сөрөн тэсвэрлэх даван туулах чадвар сэдэвт сургалтад 180 иргэнийг хамруулсан. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний дүрэмт хувцас, аранзыг шинэчлэхэд 4.6 сая төгрөг, техник, тоног төхөөрөмжийг /помп, радио холбоо, хүрз, насилк, анхны тусламжийн цүнх, богино долгионы станц/ нэмэгдүүлэхэд 4.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Сумын эрэн хайх аврах бүлгийн байрны засварт 23.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							

2.1	Аж ахуйн нэгж, байгууллага, сум, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн ажил, үйлчилгээ хүнд суртал, чирэгдэлгүй явагдах ажлыг зохион байгуулж, тайлагнах	-	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо Шийдвэрлэсэн хувь	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт ийн хэрэгжилт 91%-ийн биелэлт гарсан. Мэдээ тайланг хугацаанд 4 удаа мэдээлж ажилласан	Өргөдөл, гомдол, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байх	2023 оны 3 улирлын байдлаар бүртгэл хяналтад нийт 71 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. Өргөдөл, гомдлын дийлэнх хувийг газар олгох болон газрын гэрчилгээ гаргуулах, ногоон тэжээлийн ургамал тариалах газар хүссэн өргөдлүүд эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 91%-тай байна. Өргөдөл гомдлыг Dashinchilen.bu.gov.mn сайтаар хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн. Цахимаар ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна.	100
2.2	Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалын хууль зүйн үндэслэлийг хянуулж байх	-	Зөрчилтэй шийдвэрийн тоо	Шийдвэрийг 2 удаа хянуулан ажилласан.	Жилд 2 удаа хянуулсан байна	Сумын Засаг даргын 150 захирамж, ЗДТГ-ын даргын 40 тушаалын эрх зүйн үндэслэлийг 3 удаа хянуулан ажилласан. Зөрчил гараагүй болно.	100
2.3	Гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	19.3 сая	Гэрэлтүүлгийн тоо	Гэрэлтүүлгийг засварлах ажил хийгдсэн.	Ажлын хэсгээс боловсруулсан ажлын даалгаварын дагуу бүрэн гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	ОНХСангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд иргэн Ц.Баясгалангаар гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх, засвар арчилгаа хийх ажлыг 19.3 сая төгрөгөөр хийлгүүлсэн.	100
2.4.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажлыг зохион байгуулах	19 сая	Тарьсан мод бутны тоо	2022 онд нийт 25971 модыг тарьсан.	2023 онд төлөвлөгдсөн модыг тариалсан байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жилийн бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гаригийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласантай холбогдуулан “БҮХ НИЙТИЙН МОД ТАРИХ ӨДӨР”-ийг 2023 оны 05 дугаар сарын 19, 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сумын малчдын зөвлөгөөн, Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлийн уулзалт зэрэг арга хэмжээний хүрээнд мод тарих	100

						ажлыг зохион байгуулж, 240 иргэн 5750ш модыг цэцэрлэгт хүрээлэнд тарьсан. Нийт 15 ААН, байгууллага байгууллагын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн 560ш мод, Чилэн арвижих баялаг хоршоо, Сорог төгөл ХХК-иуд нь өөрийн эзэмшлийн талбайд 2600ш мод, нийт 110 айл өрх 1150ш модыг тариалсан байна. Мөн Батбродерс ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд цэцэрлэгт хүрээлэнг байгуулан 2022 онд 20,0 мянган модыг тариалж, 2023 онд усжуулалтын системийг суурилуулсан.	
2.5.	Хараат багийн төвийг засварлах, хашаажуулах ажлыг зохион байгуулах	27 сая	Тохижуулсан байдал	-	Ажлын хэсгээс боловсруулсан ажлын даалгаварын дагуу бүрэн хашаажуулсан байна.	Хараат багийн төвийг шинээр барих ажлыг сумын ОНХС болон иргэдийн хандив тусламжаар барьж байгуулсан. ОНХС-аас барилга барих ажилд 19 сая төгрөг, хашаажуулах ажилд 8 сая төгрөгийг зарцуулсан.	100
2.6.	Айл өрхийг нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбох ажлыг зохион байгуулах	19 сая	Холбосон гудамж, хорооллын тоо	Айл өрхийн тоо нэмэгдсэн байна.	Ажлын хэсгээс боловсруулсан ажлын даалгаварын дагуу бүрэн холбогдсон байна.	Сумын төвийн төвлөрсөн нэгдсэн дулааны шугам сүлжээнд төрийн 5 байгууллага, 14 ААН, 10 айл өрх холбогдсон. Үүнээс 2023 онд шинээр 3 ААН, 5 айл өрх нэгдсэн халаалтад холбогдсон.	100
2.7.	Албан байгууллагуудыг камержуулах ажлыг зохион байгуулах	6.5 сая	Камерийн тоо	3 камерийг нийтийн эзэмшлийн гудамж талбайд суурилуулсан байна.	Камержуулалтын ажил бүрэн хийгдсэн байна.	Засмал зам дагуу дөрвөн замын уулзвар, наран хороо, өлзийт хороо, сант хороо, цэцэрлэг хороод камержсан. Дөрвөн замын уулзварт 360 градус эргэдэг, өдөр, шөнө ялгадаг, автомашины номер татах хүчин чадалтай 1 камерыг нэмж байрлуулсан. Сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийт 7 камер ажиллаж байна. ЗДТГ, ЭМТ, ЕБС, цэцэрлэг, тусгай зөвшөөрөл	100

						бүхий ААН-үүд, 2 ахуй үйлчилгээний төв бүрэн камержсан. 2023 онд ОНХС-ийн 6,5 сая төгрөгийн хөрөнгөөр камержуулалтыг завсарлах, шинэчлэх ажил хийгдсэн.	
2.8.	Сумын төвийн хатуу хучилттай замын ажилд хяналтыг тавих	-	Гүйцэтгэлийн хувь	Сумын төвийн хатуу хучилттай замын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй.	Хяналт шалгалтыг тогтмол тавьж, ажлыг гүйцэтгэл 100 хувиар хангагдсан байна	Сумын Засаг даргын захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж сумын төвийн 1,8 км хатуу хучилттай авто замын ажилд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан, хяналт шалгалтыг тогтмол хийж ажилласан. Авто замын ажлын гүйцэтгэл 100%-тай хэрэгжсэн	100
2.9.	Холбогдох журмын дагуу улс, аймгийн аварга малчин, тариаланчдын материалуудыг хүргүүлэх	-	Журмын дагуу гаргаж хүргүүлэх	Улсын сайн малчинд 1, Аймгийн сайн малчин өрхөд 3 өрхийг тодорхойлон хүргүүлсэн.	Шаардлага хангасан материалуудыг хугацаанд хүргүүлж ажилласан байна.	2022 оны жилийн эцэст 1 малчныг улсын аварга малчинд, 1 малчныг аймгийн хошой аварга малчинд, 2 малчинг аймгийн аварга малчинд, 1 малчныг 3.Очирын нэрэмжит шагналд тус тус тодорхойлж, сар шинийн босгон дээр шагналаа гардан авсан. 2023 онд улсын аварга малчинд 2 малчин, аймгийн аварга малчинд 6 малчны материалыг хүргүүлэхээр бэлтгэж байна.	100
2.10.	Сум байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны байдлаар 80-с дээш хувиар биелсэн байна.	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн XV/02 тоот тогтоолоор Дашинчилэн сум үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтаж хийх “ДАШИНЧИЛЭН-100” бүтээлч ажлын жагсаалтыг баталж, эзэнжүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Дашинчилэн 100 бүтээлч ажлын хүрээнд 2023 онд 4.6 тэр бум төгрөгийн өртөг бүхий дотуур байрны барилга барих, цэцэрлэгийн барилгын их засвар, засмал зам, ундны усны эрэл хайгуулын ажил, орон нутаг судлах танхимын засварын ажил, соёлын төвийн лед	70

						дэлгэц, малчдын зөвлөгөөн, эрдэм шинжилгээний хурал зэрэг ажлууд хийгдсэн байна. 2024 онд улсын төсвийн 2.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээ, 200 сая төгрөгийн өртөгө бүхий хүүхдийн тоглоомын талбай, азийн хөгжлийн банк болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5.6 тэр бум төгрөгийн өртөг бүхий 15 ортой жишиг эрүүл мэндийн төвийн барилга, аймгийн төсвийн хөрөнгөөр 320 сая төгрөгийн өртөг бүхий ЕБС-ийн биеийн тамирын спорт талбай, сумын ОНХС-ийн хөрөнгөөр наадмын талбай, хүндэтгэлийн талбайн тохиожилт, цэцэрлэгт хүрээлэнгийн тохиожилт, гэрэлт гудамж байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн байна.	
2.11.	Сумын хэмжээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн тоо, хамруулсан байгууллагын тоо	-	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бүх байгууллагуудын үйл ажиллагаанд тусгай удирдамжийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээг 2 удаа зохион байгуулсан байна.	Албан байгууллагуудын тайлан мэдээний хэрэгжилтэд 2 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажилласан. Аймгийн Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хэсэгтэй хамтран байгууллагын дарга, эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, заавар зөвлөгөөг өгч ажилласан.	100
2.12.	Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх		Хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн тоо, хамруулсан	-	Нийт ТАХ-дын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг 2 удаа зохион байгуулсан байна.	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд 3 удаа үнэлгээ хийж ажилласан. 2023 оны 1-р улиралд хамт олны хурлаар төрийн албан хаагчдын 1 дүгээр улирлын ажлын тайланг сонсох ажлыг зохион байгуулсан. 2023 оны 2-р улиралд төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн	100

			ан ТAХ-н тоо			төлөвлөгөөг дүгнэн, үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан. 2023 оны 3-р улиралд ажлын байрны үзлэг шалгалтыг зохион байгуулан, үнэлэлт дүгнэлт өг ажилласан. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх ажил хийгдэж байна.	
2.13.	Иргэдийг эрүүл мэндийн даатгал болон сайн дурын даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	-	Хамрагдсан иргэдийн тоо	2022 онд нийт 1616 хүн хамрагдаж, нийт хүн амын 53.3%ийг хамруулан ажилласан байна.	Хамруулах ажлыг бодиттой зохион байгуулан, 70-ээс дээш хувиар хамруулсан байна.	Эрүүл мэндийн даатгалд хамрагсдын судалгааг баг тус бүрээр нь гаргаж, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж байна. "Хүрч үйлчлэе" аяны хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нартай хамтран ажиллаж, 234 хүн үзлэгт хамрагдсан. 10 сарын байдлаар 12158,2 төрг-ийн Эрүүл мэндийн даатгал сумын дансанд орж, 43,87 хувьтай байна.	70
2.14.	Иргэний андгай өргөх арга хэмжээг зохион байгуулах	-	16 настай иргэдийг бүрэн хамруулах	2022 онд Иргэний андгай өргөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 28 иргэн хамрагдсан.	Иргэний андгай өргөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 16 настнуудыг бүрэн хамруулсан байна.	Иргэний андгай өргөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. 39 иргэнийг хамруулсан.	100
2.15.	Үл хөдлөх эд хөрөнгийн судалгааг гаргаж, хуулийн дагуу гэрчилгээжүүлэн ажиллах	-	Гэрчилгээжүүлсэн үл хөдлөхийн тоо	хуулийн дагуу 25 иргэнд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг олгож ажилласан байна.	Гэрчилгээжээгүй үл хөдлөх хөрөнгийг бүрэн гэрчилгээжүүлсэн байна.	Үл хөдлөх эд хөрөнгийн судалгааг гаргаж, хуулийн дагуу гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан. 2023 оны байдлаар 15 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	100

2.16.	Төрийн болон ТББ, ААН-тэй хамтран суманд бүртгэлтэй ажлын байрны судалгааг гаргах, сур орон тооны мэдээллийг хүлээн авах, сул орон тоонд иргэнийг жуучлах ажлыг зохион байгуулах	-	Судлагаа тай болсон байх, хүлээн авсан сул орон тооны тоо, жуучилса н иргэний тоо	Байнгын ажлын байранд 38, улирлын ажлын байранд 7 иргэн, түр ажлын байранд 40 иргэн, нийт давхардсан тоогоор 54 иргэнийг зуучилан ажилласан байна.	Бүртгэлтэй ажлын байрны судалгаатай болсон байна. Нийт гарсан сул орон тоог бүртгэж, иргэнийг жуучилж ажилласан байна.	2023 оны 11 сарын байдлаар ажил зуучлах үйлчилгээнд 50 иргэн хамрагдсан. Байнгын ажлын байранд 38, улирлын ажлын байранд 1, түр ажлын байранд 11 иргэнийг зуучилж, хэрэгжилт 78%-тай байна. Шинэ ажлын байр 41 үүнээс байнгын ажлын байр 26, түр ажлын байр 15-ыг тус тус програмд шивсэн байна. Нийтийг хамарсан ажлын хүрээнд "Сэг зэм устгах", "Мод тарих талбайг хашаажуулах" ажилд 21 иргэнийг хамруулж 8.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна. Мөн сумын төвийн засмал зам цэвэрлэх ажилд 13 иргэнийг ажиллуулж, 5,2 сая төгрөгийн урамшууллыг олгосон. 2023 оны 05-р сард нийт 4 иргэнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 106,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Тус ажлын хүрээнд мужааны цехэд 3 ажлын байр, ахуй үйлчилгээний төвд 5 ажлын байр, аялал жуулчлалын чиглэлээр 2 ажлын байр, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 2 ажлын байр тус тус нэмэгдсэн байна. ХЭДС-н төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг хамруулж, 7 сая төгрөг, 2 өрхийг тус бүр 5 сая төгрөгийн малжуулах төсөлд хамруулсан.	100
2.17.	Иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулах	-	Мэргэжил олгосон иргэний тоо	Сургалт хийгдээгүй	Мэргэжил олгох сургалтанд 2-5 иргэнийг хамруулсан байна.	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эндээ-Хөгжил ТББ-тай хамтран тогоочийн 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 25 хүн хамрагдаж, үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан.	100

2.18.	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах	-	Эрх ашгийг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын тоо	Хяналт шалгалтыг 21 удаа зохион байгуулсан байна. Хэрэглэгчдээс 1 гомдол санал ирсэн.	Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу үйл ажиллагааг бүрэн явуулсан б-айна.	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл нь 2023 онд 4 удаа хуралдаж, хүнсний болон эрчим хүчний хэрэглээний үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажилласан байна. 2023 онд иргэдээс нийт 3 санал хүсэлт ирсэн шийдвэрлэж ажилласан.	100
2.19.	Орон нутгийн бренд бүтээгдэхүүнтэй болох	-	Брэнд бүтээгдэхүүний тоо	Булган амт Чацаргана үйлдвэрлэгдэж байна. Сумын зах зээлд нэвтрээгүй.	1-ээс дээш брэн бүтээгдэхүүнтэй болж, зах зээлд нэвтрүүлэх	Тус суманд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг Муку ХХК нь Соба гурил, Соба будааг Дашинчилэн суманд үйлдвэрлэн савалж, Монгол улсын зах зээлд гаргаад байна. Мөн Сорог төгөл ХХК, Чилэн арвижих баялаг хоршоод нь өөрийн тариалсан чацарганаар өтгөрүүлсэн чацарганыг үйлдвэрлэн савалж, худалдан борлуулж байна.	100
2.20.	Хилийн цэсийг тогтоох ажлыг зохион байгуулах	11 сая	Хилийн цэсийг тогтоосон байна.	Тодорхой ажил хийгдээгүй.	Хилийн цэсийг тогтоосон байна.	Хилийн цэсийг тогтоох ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр 9.604.0 төгрөгөөр "Сод сүрвей" ХХК -иар гүйцэтгүүлсэн.	100
2.21.	Булаг шанд хашиж хамгаалах ажлыг зохион байгуулах	20 сая	Булаг шандны тоо	Ажил хийгдээгүй.	2-3 булаг шандыг хашиж хамгаалсан байна.	2023 онд Лах багийн Түрүүний эхийн булгийг аймгийн Байгаль хамгаалах сангийн 9 сая төгрөгийн хөрөнгөөр "Есөнмөнх" ХХК нь хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хараат багийн Шандны булагийг хаших ажлыг сумын байгаль хамгаалах сангийн хөрөнгө, малчдын оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн. Байгалийг хамгаалж хог хаягдлыг бууруулах ажлын хүрээнд 1,2 сая төгрөгийг зарцуулсан.	100
2.22.	Бэлчээрийн хортон шавьж, мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах	6 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 2 удаа зохион	Төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжилт 90-с дээш хувиар биелсэн байна.	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг Улсын төсвийн 10,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хараат багт 2000 га, Лах багт 3000 га,	100

				байгуулж, 10000 га газарт хийсэн байна.		Доргонт багт 3000 га, нийт 7000 га талбайд хийсэн.	
2.23.	Байгалийн баялагийг зүй зохистой ашиглаж буй байдалд хяналт тавих, байгалийн баялагийн орлогыг бүрэн оруулах	-	Байгалий н баялагий н зүй бус ашигласа н зөрчлийн тоо, орлогын хувь	Элс, хайрга, хужрын төлбөр хураамжинд нийт 1321000 төгрөгийг оруулж ажилласан байна.	Зөрчил гараагүй байна, Орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.	2023 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 4 сая төгрөг төвлөрүүлэхээс 11 дүгээр сарын байдлаар 2,1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100 хувь төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна	100
2.24	Сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тайлагнах	-	Тогтоол шийдвэр ийн хэрэгжил тийн хувь	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 85хувьтай хангаж ажилласан.	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг 2 удаа тооцож хурлаар оруулж үнэлэлт дүгнэлт авч ажиллаж байна. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилт 88%-тай хэрэгжсэн.	100
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
3.1.	Нээлттэй хаалганы өдрийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, тайлагнах	200,0	Зохион байгуулс ан тоо, хамрагдс ан иргэдийн тоо	Зохион байгуулагүй	5. 9-р сард зохион байгуулж, 300-аас дээш иргэдийг хамруулсан байна.	Хараат, Лах, Доргонт багийн өдөрлөгөөр Нүүдлийн тамгын газар, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр малчдад малын А дансны лавлагаа олгох, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, хууль эрх зүйн мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Багийн Иргэдийн нийтийн хурлын үеэр гарын авлага материал бэлтгэн, 1200 олшруулан тарааж ажилласан. Хурлын үеэр байгууллагын үйл ажиллагааны тайлангаа тавьж, тоглолт хийсэн.	100

3.2.	“Дашинчилэн” мэдээллийн хуудсыг гаргаж иргэдэд ажлаа сурталчилах	100,0	Мэдээллийн хуудсын тоо, хүрсэн иргэдийн тоо	Дашинчилэн мэдээллийн хуудсыг 2 удаа бэлтгэн, 1200 ш олшруулан тарааж ажилласан.	2 удаагийн товхимолыг гаргаж, нийт өрхөд хүргүүлсэн байна.	Дашинчилэн мэдээллийн хуудсыг 2023 онд 3 удаа гаргаж, нийт өрхийн 70%-д хүргүүлж ажилласан.	100
3.3.	“Иргэдээ сонсьё” аяныг улирал бүр зохион байгуулж, ажлаа тайлагнадаг арга хэлбэрийг хэвшүүлэх	250,0	Зохион байгуулсан аяны тоо, хамрагдсан иргэдийн тоо	Нийт өрхийн 80%-д хүрч ажилласан.	Иргэдээ сонсох аяныг 4 удаа зохион байгуулж, сумын хүн амын 50-иас дээш хувийг хамруулсан байна.	“Иргэдээ сонсьё” нөлөөллийн ажлыг 5 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 650 иргэнд эрүүл мэнд, төр, засгийн бодлого шийдвэрийг мэдээллэх, хууль эрх зүйн зөвлөгөөг өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Мөн “Малчдыг зөвлөгөөн 2023” арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр Илтгэх урлагийн прагматик дадлагын багш Г.Бандицэрэн /Chila lector/ малчдад “Амьдралын үнэ цэнэ” сэдвийн хүрээнд суралтыг зохион байгуулж, 136 малчин хамрагдсан.	100
3.4.	Төрийн зарим чиг үүргийн дагуу төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, ажил арга хэмжээ зохион байгуулах	-	Хамтран ажилласан ТББ-ын тоо, Зохион байгуулсан ажил, арга хэмжээ тоо	Эмэгтэйчүүд, Ахмадын холбоо, Морин спорт уяачдын холбоо, ажил олгогч эздийн холбоотой хамтран 3 арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Уг арга хэмжээнд нийт	2-3 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, нийтийг хамарсан 5 ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хог ачилт, тээвэрлэлт, ундны үс түгээх ажлыг хувь иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр "Бүсгүйчүүд" тэмцээн, сумын Ахмадын холбоотой хамтран "Ахмадын баяр"-ын үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан. Мөн 2024 онд тохиох сумын 100 жилийн ойн арга хэмжээ, хандивын үйл ажиллагааг зохион байгуулах "Дашинчилэн хөгжлийн сан" ТББ-ийг шинээр байгуулаад байна.	100

				давхардсан тоогоор 1100 иргэн хамрагдсан байна.			
3.5.	Төрийн албан хаагчдын ажлын тайланг ЗДЗХ-аар хэлэлцүүлэх	-	Тайланг сонссон ТАХ-ын тоо	ЗДЗ-ийн хурлаар албан хаагчийн тайланг сонссон. 4	Бүх төрийн албан хаагчдыг бүрэн хамруулна.	Төрийн албан хаагчдын тайланг сонсголыг 1 удаа Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт өгч ажилласан. Тайланг сонсох арга хэмжээнд 15 албан хаагч 1 дүгээр улирлын тайлангаа хэлэлцүүлсэн.	100
3.6.	Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.	-	Тайланг сонссон ажлын хэсгийн тоо	Ажил хийгдээгүй.	Захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг 100 хувь хамруулна.	2023 онд сумын Засаг даргын захирамжаар 56 ажлын хэсэг байгуулагдсан судалгааг гаргаж, удирдлага болон албан хаагч нарт 2 удаа танилцуулсан.	100
3.7.	Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг төрийн албан хаагчид болон хэрэглэгчээс хагас, бүтэн жилээр авч, тооцох	-	Хамруулсан ТАХ, иргэдийн тоо	Багийн ИНХ болон нээлттэй хаалганы өдрөөр нийт 250 иргэнээс асуумж судалгааг авч ажилласан.	ТАХ-чдыг 100 хувь, 300-аас доошгүй иргэдийг хамруулна.	Багийн ИНХ болон нээлттэй хаалганы өдрөөр нийт 250 иргэнээс асуумж судалгааг авч ажилласан.	70
3.8.	Байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд ажлын тайлангаа хүргэх ажлыг зохион байгуулах	100,0	Зохион байгуулсан тоо, хамрагдсан иргэдийн тоо	Байгууллага сурталчлах ажлыг 1 удаа зохион байгуулсан.	Байгууллагын үйл ажиллагааг сурталчилах ажлыг 5 сард зохион байгуулж, 150-ээс доошгүй иргэдийг хамруулна	Сумын 4 багийн иргэдийн нийтийн хурлын үеэр байгууллагын үйл ажиллагааны тайланг тавьж, тоглолт зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 135 иргэн хамрагдсан.	100
3.9	Угтах үйлчилгээг бий болгох, ажлыг тогтмолжуулах	2,6 сая	Угтах үйлчилгээний тохижилт, угтах үйлчилгээ	Ажил хийгдээгүй.	Угтах үйлчилгээний хэсгийн тохижуулсан байна. 2023.02.01-ээс өдөр бүр угтах үйлчилгээ ажилласан байна.	Угтах үйлчилгээг тогтмолжуулан ажиллуулж байна. 2023 онд нийт давхардсан тоогоор 65 албан хаагч хамрагдан, 650 иргэнд төрийн үйлчилгээг хүргэж ажилласан байна. Угтах үйлчилгээний хэсгийг иж бүрэн тохижуулж, компьютер, принтер	100

			ажилласан өдрийн тоо			шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан.	
3.10	ВЭБ хуудас болон Facebook хуудсаар мэдээ мэдээллийг тогтмол мэдээлэх, Онцлох ажлын мэдээ, сарын мэдээллийг аймгийн ХМОНХА-д тухай бүр хүргүүлэх. Сайхан Монгол ТВ болон Булган мэдээ сонинд сумын мэдээллийг хэвлүүлэх	-	Мэдээллийн тоо	2021 онд сумын вэб хуудсыг шинэчлэн хөгжүүлсэн, Фэйсбүүк хуудсаар мэдээллэж байсан	Сайхан Монгол ТВ, Булганы мэдээ сонинд 1 удаа мэдээлэл гаргуулна. Цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	Dashinchilen.bu.gov.mn цахим сайтад шинэчлэлийг хийсэн. Цахим сайтад мэдээ, мэдээллийг цаг тухай бүр нь оруулах ажил хэвшсэн. Үндэсний дата төвд хүсэлт гаргаж, сумын ЗДТГ-ын 17 төрийн албан хаагчид албаны цахим хаягийг нээж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн ERP.E-Mongolia.mn сайтад нийт төрийн албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулж, ашиглалт жигдэрсэн.	100
3.11	ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн хэвшүүлэх	19,8 сая	ISO нэвтрүүлж, баталгаажсан байна.	-	Стандартыг нэвтрүүлж, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна.	“Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага ISO 9001:2015” стандартыг нэвтрүүлэх зорилгоор “Тэнүүн Сэтгэмж” ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан, зөвлөх үйлчилгээг авсан. Чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагад тохирсон байдалд баталгаажуулалтын аудитыг 2023 оны 06 дугаар сарын 26-28-ны хооронд Кю Сертф ХХК-тай гэрээ байгуулан хийлгэсэн. Дотоод аудитор бэлтгэх сургалтад 2 төрийн албан хаагчийг хамруулж, батламжаа гардан авсан. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхэд 19.4 сая төгрөг, дотоод аудитор бэлтгэх сургалтын төлбөрт 990.0 мян төгрөгийг зарцуулсан. Гэрчилгээг гардан авсан.	100
3.12.	Засаг даргын зөвлөлийн хурал, байгууллагын дарга нарын	-	Зохион байгуулс	Засаг даргын зөвлөлийн	Дүрмийг боловсруулсан	Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны ажлын төлөвлөгөөг	100

	хурлын дүрмийг боловсруулж, хурлын төлөвлөгөөг гаргах, хурлыг зохион байгуулах		ан хурлын тоо, хувь	хурал 13 удаа 25 асуудлыг хээлцэн шийдвэрлэн ажилласан байна.	байна. Хурлын төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувиар биелсэн байна.	боловсруулан, зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлуулан ажиллаж байна. 2023 онд хэлэлцэх ёстой асуудлын 90-ийг хэлэлцүүлсэн. Бодлогын чанартай 25 асуудлыг хэлэлцсэн байна.	
--	--	--	---------------------	---	---	--	--

Засаг даргын Тамгын газрын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 96.5%-тай хэрэгжсэн.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН
ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ХЭЗХМ Б.БАТЦЭЦЭГ
Ц.БОЛОРЦЭЦЭГ